



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 353

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,  
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 7/09 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 50,034,551.00 (тавин сая гучин дөрвөн мянга таван зуун тавин нэгэн) төгрөгийн балансын үнэ, 10,188,310.00 (арван сая нэг зуун наян найман мянга гурван зуун арван) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн харьяа Увс аймаг дахь Шүүхийн шинжилгээний албанд эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Б.Болдбаатар, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ё.Мөнхзул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн  
33 дугаар тогтоолын хавсралт

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ  
ХҮРЭЭЛЭНГИЙН ХАРЬЯА УВС АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ  
АЛБАНД ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон, дахин үнэлсэн он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ахмадын хорооны хуучин конторын барилга	1954/2018	м2	290	18,611,094.00	9,305,547.00	9,305,547.00
2	Гарааш	2008/2018	м2	43	1,092,420.00	327,726.00	764,694.00
3	Газар эзэмших эрх	2018	м2	1,488.80	29,776,000.00	-	29,776,000.00
4	Банзан хашаа	2013/2018	м	96	269,619.00	269,619.00	-
5	Төмөр хашаа	2008/2018	м	48	285,418.00	285,418.00	-
Нийт дүн					50,034,551.00 (тавин сая гучин дөрвөн мянга таван зуун тавин нэгэн)	10,188,310.00 (арван сая нэг зуун наян найман мянга гурван зуун арван)	39,846,241.00 (гучин есөн сая найман зуун дөчин зургаан мянга хоёр зуун дөчин нэгэн)